

Мэдрлийн эмчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн шалгалтын жишиг сорил

Сорил-1

Сонгогдсон сорил

1. Нэг сонголттой тест (Зөвхөн 1 хариулт зөв байх) Энэ хэлбэрийн сорил нь А, В, С, D, E гэсэн дугаартай бөгөөд Зөвхөн 1 зөв хариуг сонгоно.
2. Олон сонголттой тест (Хэдэн ч хариулт зөв байж болох)
 - 1, 2, 3 дугаар хариултууд зөв бол (А.)
 - 1 ба, 3 дугаар хариултууд зөв бол (В.)
 - 2 ба 4 дугаар хариултууд зөв бол (С.)
 - Зөвхөн 4-р хариулт зөв бол (D.)
 - Бүх хариулт зөв бол (E.)
3. Шалтгаан хамаарлын тест (Заагдсан тестүүдийн үнэн зөв хийгээд тэдгээрийн шалтгаан хамаарлыг тодорхойлно.)
 - Зөв, Зөв, Зөв (А.)
 - Зөв, Зөв, Буруу (В.)
 - Зөв, Буруу, Буруу (С.)
 - Буруу, Зөв, Буруу (D.)
 - Буруу, Буруу, Буруу (E.)

/1./ Сэтгэцийн эмгэгтэй хүнийг харах хандах үүрэгтэй асран хамгаалагч асрах үүргээ умартаж тухайн өвчтөнийг дэр мэдэн эмнэлгээс гарган явуулсан тохиолдолд уг этгээд нийгэмд аюултай үйлдэл хийвэл хариуцлага алдсан этгээд ямар хуулийн зүйл ангиар хариуцлага хүлээлгэх вэ?

- A. ЭХ-ийн 263 дугаар зүйлд заасан байдаг
- B. ЭХ-ийн 265 дугаар зүйлд заасан байдаг
- C. ЭХ-ийн 269 дугаар зүйлд заасан байдаг
- D. ЭХ-ийн 262 дугаар зүйлд заасан байдаг
- E. ЭХ-ийн 267 дугаар зүйлд заасан байдаг

/2./ Хүний хэлснийг ойлгох боловч, өөрөө ярьж чадахгүй. Залгих рефлекс хэвийн.

- A. Ойлгохын хэлгүйдэл
- B. Ярихын хэлгүйдэл
- C. Анартри
- D. Дизартри
- E. Бульбар саа

/3./ Залуу оройн хоолны дараа гэнэт толгой өвдөж, огъж бөөлжиж, ухаан алдаж, хүлээн авах тасагт хүргэгдсэн. Ходоод цэвэрлэх, хордлого тайлах эмчилгээнд үр дүнгүй. Зайлшгүй илрүүлэх хамшинж:

- A. Пирамидын
- B. Сул сааны
- C. Полиневропатийн
- D. Ёзоорын
- E. Мэнэнгийн

/4./ Нэг настай хөхүүл хүүхдийн толгойн тойрог 40см. Нүүр толгойн харьцаа алдагдсан. Байнга уйлагнана. Таны урьдчилсан онош:

- A. Микроцефали
- B. Гидроцефали
- C. Макроцефали
- D. Дизэмбриогенези
- E. Гипоксийн энцефалопати

/5./ Нугасны өмнөд эврийн гэмтлийн шинж тэмдэг

- A. Захын саа
- B. Хорнерын шинж
- C. Төвийн саа

D. Хуурамч бульбар саа

E. Бульбар саа

/6./ Сул сааны үед гэмтэх бүтцүүд

A. Нугасны арын эвэр

B. Нугасны өмнөд эвэр

C. Нугасны хажуу эвэр

D. Ganglion spinal

E. Premotor cortex

/7./ 2 хөл хөдлөхгүй. Бабинскийн рефлекс тод. Шээс хоригдсон. Өсгий цооролттой.

A. нугасны тал гэмтэл th5-7

B. нугасны бүтэн гэмтэлth 5-7

C. адуун сүүлийн хамшинж

D. нугасны өмнөд эврийн гэмтэл L3-L5

/8./ Баруун гар унжсан, мөр бугалганы булчин шуурч хатингиршсан. 2 ба 3 толгойт булчингийн шөрмөсний рефлексүүд үүсэхгүй. Мэдрэхүй хэвийн.

A. Нэг мөчний чангарсан саа

B. Нэг мөчний сул саа

C. Дежерин-Клюмпке-гийн саа

D. Эрба-Дюшенны саа

E. Сувгийн хамшинж

/9./ 3 настай охин, хоолтой холбоогүй үе үе бөөлжиж, явахдаа гуйвах болсон. Орчны сонирхол тааруу. Нүд дотогш хялар. Өвчин богино хугацаанд даамжирсан

A. Энцефалит

B. Литтлын хамшинж, хүүхдийн тархины саа

C. Марфаны хамшинж

D. Бага тархины хавдар

E. Лейкодистрофи

/10./ Хүний сэтгэхүй хэдээс хэдэн насны хооронд бүрэлдэн тогтдог вэ?

A. 20-25

B. 18-22

C. 22-25

D. 20-22

E. 18-25

/11./ Сегментын хэвшинжийн мэдрэхүйн өөрчлөлт

A. Нугасны арын эвэр

B. Нугасны өмнөд эвэр

C. Нугасны хажуу эвэр

D. Ganglion spinal

E. Premotor cortex

/12./ Баруун гар огт хөдлөхгүй, тонус, гүний рефлексүүд арилсан. Мэдрэхүй хэвийн.

A. сул саа

B. чангарсан саа

C. талсаа

D. тэнцвэргүйдэл

E. анестези

/13./ Ахмад настай эрэгтэй хүнд юм өргөх үед цээжээр хатгаж, амьсгаа авах, найтах, ханиахад түвэгтэй. Зүрхний бичлэг хэвийн. АД 130/80мм.МУБ. Таны урьдчилсан онош:

A. Ёзоор татагдлын өвдөлт

B. Зүрхний бах

C. Уушигны багтраа

D. Бүсэлхийн радикулопати

E. Архаг бронхит

/14./ Унтаад сэрэхэд баруун гарын сарвуу унжсан. I,У хурууг ойртуулах боломжгүй. Гэмтэл бэртэлд ойрд өртөөгүй. Үзлэгээр: Сарвуугаа гэдийлгэж чадахгүй. Сарвууны ар тал I-III хурууны харалдаа өвдөлтийн мэдрэхүй буурсан. Таны урьдчилсан онош:

A. Мөрний сүлжээний доод салааны эмгэг

- B. n.radial гэмтсэн
C. Мөрний сүлжээний дээд салааны эмгэг
D. n.ulnar гэмтсэн
E. n.median гэмтсэн
- /15./ Хэлээ амнаас гүйцэд гарахгүй, хахаж цацна. Хэлний булчин хатингир.
A. Бульбар саа
B. Хуурамч бульбар саа
C. Хэлний дорхи мэдрэлийн саа
D. Хэл залгиурын мэдрэлийн ян
E. Зажлуурын булчингийн саа
- /16./ Гарын сарвуу, тавхайн хүч буурч, булчингууд хатингиршсан. Тэнцвэр муу, харанхуйд илүү бүдчинэ. Хамшинжийн онош:
A. Ёзоорын хамшинж
B. Полиневритын хамшинж
C. Дөрвөн мөчний сул саа
D. Тэнцвэргүйдэл
E. Мононеврит хамшинж
- /17./ Өсвөр насны залуу зүүн хөлөө чирж явна, нуруу хазайсан. 2 хөлийн гуя, өгзөгний булчин хатингар, зүүн талдаа илүү шуурсан. Зүүн хөлийн хөгжил хоцорсон.
A. Энцефалитын үлдэц
B. Полиомиелитын үлдэц
C. Нугасны амиотрофи, Вердниг-Гоффманы хэлбэр
D. Нугасны амиотрофи, Кугелберг-Ведандерын хэлбэр
E. Миелопати
- /18./ Зүүн гар бугуйн үеэр хөдлөхгүй, бугалга шууны дотор талаар чиг хуруу чиглэж өвдөлтийн мэдрэхүй буурсан. Гар янгинаж өвдөнө.
A. нугас өмнөд эвэр C5-C7
B. нугасны арын эвэр C 5-C7
C. мөрний сүлжээ C7-Th1
D. мөрний сүлжээ C5-C6
E. нугасны бүтэн огтлол C5-C6
- /19./ Зүүн нүдний ухархай руу цоргиж, хатгаж өвдөнө. Хүчтэй өвдөлтийн дараа нүднээс нулимс гоожиж, гэрэлд гялбасан. Нүдний эвэрлэг, дух, хуйханд цэврүүт тууралт гарч, шархалсан. Баруун нүд гүйцэд анигдахгүй. Баруун хацраар хий алдана.
A. Гурвалсан мэдрэлийн ян
B. Глаукомын хөдлөл
C. Гассер зангилааны өвдөлт
D. Мигренийн хөдлөл
E. Эвэрлэгийн үрэвсэл
- /20./ Баруун гар, мөр, цээжний баруун хагаст өвдөлт, t° мэдрэхүй арилсан. Мэдрэхүй алдагдсан хэвшинж:
A. Ёзоорын хэвшинж
B. дисталь хэвшинж
C. Сегментын хэвшинж
D. Дамжих хэвшинж
E. Мононеврит хэвшинж
- /21./ Хавирганы нум орчмоор хатгаж өвдөнө. Өвдөлт амьсгал авах, найтаахад ихэснэ. Хэвлийн дээд рефлекс үүсэхгүй.
A. Ёзоорын хамшинж
B. Хавирга завсрын мэдрэлийн өвдөлт
C. Бүслүүр ярын ян
D. Уушигны хатгалгаа
E. Цээжний өвдөлт
- /22./ Баруун үе үе татагнаж булчин татна. Аажмаар суларч, явахад чирэгдэнэ. Бабинскийн рефлекс баруунд тод. Өвдөг, борвины рефлекс өндөр d>s.
A. өмнөд төв атираа зүүнд

- B. арын төв атираа зүүнд
- C. нугасны арын эвэр L1-L5
- D. нугасны өмнөд эвэр L1-L5
- E. нугас талласан L1-L5

/23./ Хуурамч бульбар сааны үед гэмтэх бүтцүүд:

- A. IX,X,XII хосын бөөмс
- B. IX,X,XII хосын кортико-нуклеар зам
- C. IX,X хосын мэдрүүл
- D. Nucleus dorsal
- E. Nucleus ambiguus

/24./ Сэтгэлийн хөдөлгөөн тогтворжуулах эмийг нэрлэнэ үү?

- A. Амитриптиллин
- B. Галоперидол
- C. Лити карбонат
- D. Амисулпирид
- E. Зуклопентоксил

/25./ Баруун гар тохойгоор нугарч, сарвуу дотогш эргэсэн. Баруун хөл явахад чирэгдэж даялна.

- A. Вернике-Маннхын байрлал
- B. Ромбергхын тэнцвэргүйдэл
- C. Steppage алхаа
- D. “Тамгалсан алхаа”
- E. “Мэлхий байрлал”

/26./ Цээжний баруунд эгмээс хавирганы нум хүртэл өнгөц, t° мэдрэхүй буурсан. Мэдрэхүй алдагдсан хэвшинжийг нэрлэнэ үү.

- A. Дамжих хэвшинж
- B. Хязгаарын хэвшинж
- C. Ёзоорын хэвшинж
- D. Сегментын хэвшинж
- E. Дисталь хэвшинж

/27./ Өглөө сэрэхэд баруун сарвуу унжсан. Урьд орой нь архи уусан. Таны тавих урьдчилсан онош:

- A. N.radial невропати
- B. Тохойн сувгийн хамшинж
- C. Мөрний сүлжээний эмгэг
- D. N.medianus невропати
- E. Полиомиелит

/28./ Хөхүүл охин, 6 сартай, толгойн тойрог 47см. Их зулай том, чинэрч лугшина. Грефе-н шинж тод үүснэ.

- A. Гавлын даралт ихсэлт-тархи усжилтын хамшинж
- B. Сульдаа
- C. Бамбайн хордлого
- D. Тэжээлийн доройтол
- E. Мэдрэл хордлогын хамшинж

/29./ Сул сааны шинжүүд

1. Булчингийн хатингирал
2. Булчингийн тонус буурах
3. Шөрмөсний рефлекс арилах
4. Эмгэг рефлекс
5. Мэдрэхүй буурах

/30./ Паркинсонизмын шинжүүд

1. Нүүрний баясал буурах
2. Хүчилж уйлах
3. Бөгтийх галбир
4. Том алхаа
5. Хэлгүйдэл

/31./ Хязгаарын мэдрэл эмгэгших шалтгаан

1. Чихрийн шижин
2. Алкоголь
3. Порфири
4. Хими эмчилгээ
5. Уреми

/32./ Хөлөө зайтай тавьж гуйваж явна. Хөл гарын хөдөлгөөн чөлөөтэй. Юм авахдаа гар салгалж чичирнэ. Хөндлөн нистагм 2 талд үзлэгээр илрэв. Бичгийн хэлбэр өөрчлөгдсөн. Хамшинжийн оношийг тогтоох.

1. Тэнцвэргүйдэл
2. Интенцийн салганал
3. Нистагм
4. Мегалографи
5. Бага тархины хамшинж

/33./ Сонсгол буурах шалтгаан

1. Отосклероз
2. Холеостеома
3. Невропати N.cochlear
4. Хэнгэргийн эмгэг
5. Бага тархи гүүрийн хавдар

/34./ 2 хөл хөдлөхгүй боловч, ханиах найтаах үед угсарч татагнана. Шээс, өтгөн задгай. Бабинскийн рефлекс 2 талд тод. Хүйснээс доош өвдөлт, халуун хүйтэн, гүний мэдрэхүй арилсан.

1. Доод мөчний чангарсан саажил
2. Мэдрэхүй дамжих хэвшинжээр алдагдсан
3. Аарцгийн эрхтэний хямрал
4. Нугас цээжний түвшинд гэмтсэн
5. Нугасны автоматизм

/35./ Нугалмайн эмгэгийн шалтгаан

1. Нугалмайн спондилез
2. Сүрьеэгийн спондилит
3. Нугалмайн хугарал
4. Нугасны ишеми
5. Сирингомиели

/36./ Бага тархины тэнцвэргүйдэл

1. Адиадохокенез
2. Булчингийн гипотони
3. Мегалографи
4. Нистагм
5. Ромбергийн шинж

/37./ Настантай харилцах онцлогийг дурьдана уу?

1. Анхааралтай сонсож харилцах
2. Үнэт зүйлсийг нь хүндэтгэх
3. Сэтгэл хөдлөлийг мэдэрч харилцах
4. Хөгжөөх, тоглох
5. Асран хамгаалагчаар нь дамжуулан харилцах

/38./ Өсвөр насны хүү шатаар өгсөх, гүйхэд бэрхшээлтэй. Тулж өндийнө. Нуруу хотгор, хэвлий цүндгэр. Биеийн жин аажим буурсан. Эрээн булчин хатуурч чангарсан. Шөрмөсний рефлексүүд арилсан. Таны урьдчилсан онош:

1. Чангарсан сааны хамшинж
2. Миодистрофи Эрба-Ротын
3. Шарко-Мари-Туттын өвчин
4. Сул сааны хамшинж
5. Хязгаарын мэдрэлийн эмгэгшил

/39./ Духны өмнөд атирааны эмгэг

1. Жексон таталт

2. Нэг мөчний чангарсан саа
 3. Нүүр-хэл-мөрний саа
 4. Эпилепсийн бага уналт
 5. Мэдрэхүйн өөрчлөлт
- /40./ Их тархины гадрын өөрчлөлт
1. Аграфи
 2. Агнози
 3. Алекси
 4. Апракси
 5. Анозогнози
- /41./ Тахалт энцефалитын цочмог үед илрэх нойрны өөрчлөлтүүд
1. Нойргүйдэл
 2. Нойрмог унтаа
 3. Нойр солигдох
 4. Нойронд явах
 5. Зүүд
- /42./ Мэнэнгийн хамшинж
1. Дагзны булчингийн хөшингө
 2. Лессажийн шинж
 3. Брудзинскийн дээд, доод шинж
 4. Дуу чимээ, гэрэлд мэдрэг
 5. Бөөлжилт
- /43./ Хэл ярианы төвийн бүтцүүд
1. Гешлийн атираа
 2. Брокийн төв
 3. Gyrgus Cuneatus
 4. Верникийн төв
 5. Gyrgus Postcentral
- /44./ Туреттийн хамшинжийн эмчилгээнд хамгийн үр дүнтэй эмүүдийг сонгоно уу?
1. Амитриптиллин
 2. Люминаль
 3. Седуксин
 4. Галоперидол
 5. Ноотропил
- /45./ Хэлээ амнаас гүйцэд гаргахгүй, өөрөө ярьж чадахгүй. Шүлс ихээр гоожно. Аяндаа уйлна. Мэдрэлийн хамшинжийг тодорхойлно уу.
1. Анартри
 2. Гиперсаливази
 3. Хүчилж уйлах
 4. Хахаж цацах
 5. Хуурамч бульбар
- /46./ Цус харвалтын шалтгаан
1. Артерийн гипертензи
 2. Судасны цүлхэн
 3. Цусны эмгэг
 4. Паркинсонизм
 5. Атеросклероз
- /47./ Нүд хөдөлгөгч мэдрүүлүүд
1. N.oculomotor
 2. N.maxillar
 3. N.abducens
 4. N. mandibular
 5. N.facial
- /48./ Угаарын хийн хордлого
1. Карбоксигемоглобины түвшин өндөр
 2. Оксигемоглобины түвшин өндөр

3. Уул уурхайн ажилтнууд өртөмхий
4. Хими цэвэрлэгээний ажилтнууд өртөмхий
5. Ухаан алдалт гүнзгий

/49./ 80 настай эмээ анх удаа арагш нумарч гэдийж, ухаан алдаж татсан. Таталтын үед нүүр хөхөрч, булчингууд хөвчирсэн, дороо шээсэн. Таталт 10мин орчим үргэлжилж, шууд хурхиран нойрссон. Гар, хөлийн хөдөлгөөн чөлөөтэй. Мэнэнгийн шинж тэмдэггүй. Ийм хөдлөл анх удаа тохиолдож байгаа бөгөөд хэд хоног нойр муутай байсан. Үзлэгээр мэдрэлийн голомтот шинж илрээгүй. Таны урьдчилсан онош:

1. Муужралт
2. Ерөнхий хүчилж чангарсан таталт
3. Хэсэгчилсэн чичирхийлсэн таталт
4. Эпилепси
5. Зүрхний дутагдал

/50./ Толгой өвдөж огъж бөөлжинө. Нүдний угт харааны мэдрүүлийн хөхлөг хөөж хавагнасан. Хамшинжийг тодорхойлох

1. Тархины ерөнхий шинж
2. Мэнэнгийн хамшинж
3. Гавлын дотоод даралт ихсэх хамшинж
4. Тархины харвалт
5. Тархины хавдар

/51./ Залуу эмэгтэй ханиад хүрсний дараа 2 нүд 7 хоногийн зайтай сохорсон. Энэ тохиолдолд онош тодруулах зайлшгүй шинжилгээ:

1. VEP(Visual Evoked Potential)
2. Тархины КТ
3. Нүдний уг
4. ЭЭГ
5. ДСГ

/52./ Бага тархины бүтцүүд

1. Nucleus dentatus
2. Tr. Spino-cerebellar
3. Vermis
4. Tr. reticulo-spinal
5. Tr. Vulbo-spinal

/53./ Эрх танхи хүмүүжлээс үүсч болох сэтгэцийн эмгэгийг нэрлэнэ үү.

1. Сүрдүүлэх хариу урвал
2. Диссоциатив эмгэг
3. Ээрэх эмгэг
4. Айдсын эмгэг
5. Өвчирхөх эмгэг

/54./ Гүрээний дотор артерийн ТИА -ийн шинж тэмдэг

1. хэл ээдрэх
2. нүүр, ухуул бадайрах
3. хамар уруулын нугалаа гөлийх
4. хөндлөн нистагм
5. хахаж цацах

/55./ Тархины гэмтлээс хойш 10 хоногийн дараа гэнэт ухаан алдаж, толгой, нүд баруун тийш гилжийж татсан. Таталтын дараа хүүхэн хараа баруун талд өргөсөж, зүүн гар хөл суларсан. Үзлэгээр: ухаан самуурсан, өөдөөс эсэргүүцнэ. Зүүн гараа зөвхөн тохойгоор нугална. Зүүн хөл хөдлөхгүй. Бабинскийн рефлекс зүүнд үүснэ. Дагзны булчин 2 хуруу хөшингө. Кернигийн шинж баруунд үүснэ. Мэдрэлийн хамшинжийг тодорхойлно уу.

1. Тархины ерөнхий шинж
2. Талласан саа
3. Мэнэнгийн хамшинж
4. Анизокори
5. Хатуу хальсны дорхи цус хуралт

/56./ Өсвөр насны охин явахдаа 2 талруу ганхаж, шатаар тулж хүчилж өгсөнө. Нуруу хотгор, хэвлийн цүндгэрдүү. Гар хөлийн хүч сул, булчин хатингар.

1. Булчингийн хатингирал
2. Бүсэлхийн хэт хотойлт
3. “Шаталж өндийх” шинж
4. Шөрмөсний рефлексүүд эрт арилах
5. Миодистрофи

/57./ Сэтгэлзүйн хоригтой хүн ямар онцлогтой вэ?

1. Айдаст автсан
2. Сэтгэл түгшилттэй
3. Гутранги үзэлтэй
4. Эргэлзэн тээнэгэлзлэх бодолтой
5. Ичиж зовох мэдрэмжтэй

/58./ Гурвалсан мэдрэлийн эмгэг

1. Зажлуурын булчин хатингирших
2. Янгийн өвдөлт
3. Ам ангайх хязгаарлагдах
4. Хацар унжих
5. Нулимс гоожих

/59./ 2 гарын булчин хатингир, мөрнөөс дээш өргөхгүй. 2 хөл солбисон, тонус өндөр, Тойг, тавхайн клонус тод. Шээс баас хоригдож, өсгий цоорсон.

1. Нугасны эмгэг C1-C4
2. Нугасны эмгэг C5-th1
3. Дөрвөн мөчний чангарсан саа
4. Дөрвөн мөчний холимог саа
5. Дөрвөн мөчний сул саа

/60./ Чангарсан сааны шинжүүд

1. Булчингийн хатингирал
2. Булчингийн тонус ихсэх
3. Шөрмөсний рефлекс арилах
4. Эмгэг рефлекс
5. Мэдрэхүй буурах

/61./ Амьсгалын дээд замын халдварын шинж илрээд 2 хоносны дараа хөхүүл хүүхэд гэнэт ихээр халуурч, бөөлжиж, татсан. Лессажийн шинж тод. Дагзны булчин хөшингө. Гэрэл дуу чимээнд маш мэдрэг.

1. Тархины ерөнхий шинж
2. Халдварын шинж
3. Мэнэнгийн шинж
4. Мэдрэл хордлогын хамшинж
5. Тархины буглаа

/62./ Нугас хөндлөн огтлолоор гэмтдэг эмгэгүүд

1. Нугасны хавдар
2. Нугалмайн хугарал
3. Сүрьеэгийн спондилит
4. Миелит
5. Нугасны буглаа

/63./ Гуяны урд талаар иржигнэж бадайрна. Үзлэгээр: мөчдийн хөдөлгөөн чөлөөтэй, өвдөгний рефлекс зүүнд үүсэхгүй. Гуяны урд өвдөгний дотор, шилбэний гадна талаар өвдөлтийн мэдрэхүй бага зэрэг буурсан.

1. Нугасны ёзоор дарагдал L3/L4
2. Нугасны ёзоор дарагдал L5/S1
3. Ёзоорын хэвшинжээр мэдрэхүй буурсан
4. Хязгаарын мэдрүүлийн хэвшинжээр мэдрэхүй буурсан
5. Невропати n. Sciatic

/64./ Духны хойд атирааны эмгэг

1. Мэдрэхүйн жексон хөдлөл

2. Ам хошууны автоматизм
3. Нэг мөчний анестези
4. Нэг мөчний саа
5. Тэнцвэргүйдэл

/65./ Мэдрэхүйн хүрээний өөрчлөлт

1. Дизестези
2. Гипералгези
3. Гиперестези
4. Гиперпати
5. Анестези

Олон сонголттой тест (Хэдэн ч хариулт зөв байж болох)

- 1, 2, 3 дугаар хариултууд зөв бол (А.)
- 1, 2, 3, 4 дугаар хариултууд зөв бол (В.)
- 2 ба 4 дугаар хариултууд зөв бол (С.)
- Зөвхөн 4-р хариулт зөв бол (D.)
- Бүх хариулт зөв бол (E.)

/66./ Голомт хаана байрлахад шээс барихгүй шинж гарах вэ?

- A. Төв атирааны хажуугийн дэлбэнцэр
- B. Нугас хүзүүний түвшинд
- C. Нугас доод бүдүүрлийн түвшинд
- D. Адуун сүүл
- E. Тархины багана гүүрийн түвшинд

/67./ Баруун хөл үе үе татагнаж булчин татна. Аажмаар суларч, явахад чирэгдэнэ. Бабинскийн рефлекс баруунд тод. Өвдөг, борвины рефлекс өндөр $d>s$. Байршилын онош тавина уу

- A. өмнөд төв атираа зүүнд
- B. арын төв атираа зүүнд
- C. нугасны арын эвэр L1-L5
- D. нугасны өмнөд эвэр L1-L5
- E. нугас талласан L1-L5

/68./ Аалзавчийн дорхи цус харвалттай өвчтөний судасны агшилтыг хянахад аль нь илүү ач холбогдолтой вэ?

- A. Ангиографи
- B. Тархины цахилгаан бичлэг
- C. Компьютер томографи
- D. Транскраниаль доплерографи
- E. Соронзон резонанст томографи

/69./ 42 настай эмэгтэй, ажил дээрээ төдийгүй нийтийн унаанд үе үе хэт нойрмоглож унтдаг. Нэг удаагийн уналт 10-15 мин үргэлжилнэ.

- A. Эпилепси
- B. Диссомни
- C. Невроз
- D. Абсанс
- E. Нарколепси

/70./ Мигрений статусын эмчилгээнд хамгийн тохиромжтой эм:

- A. Эрготамины бүлгийн
- B. Өвчин намдаах
- C. Гистамины эсрэг бүлгийн
- D. Серотонины эсрэг
- E. Таталтын эсрэг

/71./ Булчингийн тонус ихсэх тохиолдлыг сонгох:

- A. Стриатум гэмтэхэд
- B. Бага тархи гэмтэхэд
- C. Захын хөдөлгөгч нейрон гэмтэхэд

- D. Төвийн хөдөлгөгч нейрон гэмтэхэд
E. Нугасны хажуу эврийн бөөм гэмтэхэд
- /72./ Өвчтөний дуу гуншаа, хахаж цацна, хэл дультраа, залгиурын рефлекс үүсэхгүй, 4 мөчний саатай бол голомт хаана байрлах вэ?
A. Тархины хөл
B. Гүүр
C. Уртавтар тархи
D. Дунд тархины дээвэр
E. Гипоталамус
- /73./ Тархмал хатуурлын сэдрэлээс сэргийлэх эмчилгээнд уух эмийг нэрлэнэ үү.
A. Бетаферон
B. Метилпреднизолон
C. Габапентин
D. Натализумаб
E. Лирика
- /74./ Өвчтөн хоёр тийш ганхаж явна. Ямар өвчний үед ингэж явдаг вэ?
A. Нугасны хатангирал
B. Чихрийн шижингийн полиневропати
C. Шарко-Мари амиотрофи
D. Булчингийн даамжрах хатингарал
E. Бага тархины миоклоник тэнцвэргүйдэл
- /75./ Өвчтөн орон зайн баримжаалах чадвараа алдсан. Саажсан зүүн гар, хөлөө мэдрэхгүй. Үе үе гар, хөлөө эрнэ.
A. Тэнэгрэл
B. Чамархайн дэлбэнгийн гэмтэл
C. Зулайн дэлбэнгийн гэмтэл
D. Духны дэлбэнгийн гэмтэл
E. Орон зайн агнози
- /76./ Залуу эмэгтэй, төрсний дараа гэнэт баруун нүдний хараа муудсан. 1 сарын дараа зүүн нүд сохорсон. Энэ үед 2 хөл саажиж, шээс, өтгөн хоригдсон.
A. Харааны мэдрэлийн үрэвсэл
B. Истерийн саа
C. Оптикомиелит
D. Тархмал хатуурал
E. Тархины хавдар
- /77./ Хүүхэн хараа нэг талд өргөссөн, гэрлийн урвал сул, зохицох дотогшлох урвал хэвийн. Хам шинж:
A. Бернар-Горнерын хам шинж
B. Аргайл-Робертсын хам шинж
C. Аргайл-Робертсын эсрэг хам шинж
D. Нотнагелийн хам шинж
E. Бенедиктийн хам шинж
- /78./ Гурван настай хүүхдийн хөдөлгөөн аажим эвсэл муутай болж, гуйвах болсон. Бүдэрч унана. Хааяа бөөлжинө.
A. Медуллобластома
B. Аажим явцтай энцефалит
C. Фридрейхын өвчин
D. Шарко-Марийн өвчин
E. Миопати
- /79./ Уруул-амны эмгэг рефлекс аль зам гэмтэхэд гарах вэ?
A. Cortico-spinalis
B. Cortico-nuclearis
C. Fronto-ponto-cerebellaris
D. Rubrospinalis
E. Spino-cerebellaris anterior

- /80./ Чихрийн шижинтэй өвчтөний зүүн завьж унжиж, нүд анигдахгүй болсон, баруун гар хөл суларсан. Хам шинж
- A. Таламусын хам шинж
 - B. Капсулын хам шинж
 - C. Мийяр-Гублерын хамшинж
 - D. Веберын сүлжээ саа
 - E. Джексоны сүлжээ саа
- /81./ Харааны замын зөрлөг хийгээгүй ширхэгүүд гэмтэхэд харах талбайн ямар өөрчлөлт гарах вэ:
- A. Нэг талын ижил нэрийн талласан хараагүйдэл
 - B. Бүрэн бус талласан хараагүйдэл
 - C. Ижил бус нэрт битемпорал талласан хараагүйдэл
 - D. Ижил бус нэрт биназал талласан хараагүйдэл
 - E. Бүх талаас жигд нарийссан хараагүйдэл
- /82./ Нүдний ухархай руу хүчтэй төөнөж, цоргиж үе үе хатгана. Зүүн нүднээс нулимас гоожно. Эвэрлэгийн рефлекс зүүнд үүсэхгүй.
- A. Нүдний эвэрлэгийн үрэвсэл
 - B. Гурвулсан мэдрэлийн ян
 - C. Толгойн талласан өвдөлтийн нүдний хэлбэр
 - D. Глаукома
 - E. Хантын хамшинж
- /83./ Гурвалсан мэдрэлийн янгийн үндсэн эмчилгээ
- A. Мэс засал
 - B. Эмийн хориг
 - C. Диклоденк
 - D. Карбамазепин
 - E. Люминал
- /84./ Эпилепситэй жирэмсэн эмэгтэйд илүү тохиромжтой эмийг нэрлэх:
- A. Фенобарбитал
 - B. Фенитоин
 - C. Карбамазепин
 - D. Клоназепам
 - E. Депакин
- /85./ Өвчтөний зүүн талын нүүрний мэдрэл саажсан, зүүн нүд дотогш хялар, баруун талд эмгэг рефлекс илрэнэ. Голомт хаана байрлах вэ?
- A. Гүүр-бага тархины булан зүүнд
 - B. Бага тархины баруун хагас бөмбөлөг
 - C. Тархины багана зүүнд гүүрний түвшинд
 - D. Зүүн чамархайн ясны орой хэсэгт
 - E. Тархины хөлд
- /86./ Хуурамч бульбар сааны үед гэмтэх бүтцүүд
- A. IX, X, XII хосын бөөмс
 - B. IX, X, XII хосын кортико-нуклеар зам
 - C. IX, X хосын мэдрүүл
 - D. Nucleus dorsal
 - E. Nucleus ambiguus
- /87./ Суудлын мэдрэлийн татагдлын шинж:
- A. Вассерманы шинж
 - B. Неригийн шинж
 - C. Кернигийн шинж
 - D. Ласегийн шинж
 - E. Ласеж шинж
- /88./ Явахдаа өлмийгөөр шал цохино. “Тэмээн хяруулын хөлийн шинж” илэрнэ. Тавхайн хэлбэр өөрчлөгдөж, улны нум гүнзгийрсэн.
- A. Бага шилбэний мэдрэлийн невропати
 - B. Их шилбэний мэдрэлийн невропати

С. Шарко-Марийн полиневропати

D. Полиомиелитийн үлдэц

Е. Фридрейхийн тэнцвэргүйдэл

/89./ Чихрийн шижинтэй өвчтөний зүүн завьж унжиж, нүд анигдахгүй болсон, баруун гар хөл суларсан. Урьдчилсан онош

A. Чихрийн шижингийн невропати

B. Тархины талбөмбөлгийн цус харвалт

C. Тархины талбөмбөлгийн шигдээс

D. Цус хомсрох дайрлага

E. Тархины баганы шигдээс

/90./ Нугасны хатгалт хийсний дараа илрэх “нугас шаантаглах” шинжийн илрэл:

A. Ёзоорын өвдөлт гүрээний судсан дээр дарахад нэмэгдэнэ

B. Хэвлийн орчим дарахад голомтот шинж нэмэгдэнэ

C. Толгойг бөхилгөхөд ёзоорын өвдөлт нэмэгдэнэ

D. Нугасны хатгалтын дараа голомтот шинж нэмэгдэнэ

E. Толгой өвдөлт илэрнэ

/91./ Чихний гадна суваг дагуу шүүсэрхэг тууралттай, сонсгол-тэнцвэрийн үйл ажиллагаа алдагдсан тохиолдолд голомт аль зангилаанд байрлах вэ?

A. Вестибуляр

B. Далавч-тагнайн

C. Өвдгөн

D. Гассер

E. Одон

/92./ Зүүн хөлийн үзүүрээс эхэлж таталт бүх биеийг хамарна. Голомт хаана байна вэ?

A. Баруун урд адверсив талбай

B. Баруун хойд төв атирааны дээд хэсэг

C. Баруун урд төв атирааны доод хэсэгт

D. Баруун урд төв атирааны дээд хэсэгт

E. Баруун хойд төв аритааны доод хэсэг

/93./ Тархины харвалттай өвчтөнийг тээвэрлэх эсрэг заалт:

A. Ухаан алдсан

B. Давтан бөөлжсөн

C. Сэтгэц-хөдөлгөөний хөөрөлтэй

D. Зүрхний инфаркт

E. Уушигны хаван

/94./ Өндрөөс унасны дараа өвчтөний баруун тавхай унжиж, эрээн булчин шуурсан. Борвины рефлекс үүсэхгүй.

A. Суудлын мэдрэлийн невропати

B. Их шилбэний невропати

C. Гуяны невропати

D. Бага шилбэний невропати

E. Нугасны саа

/95./ Хагас бөмбөлгийн харцны саажил (өвчтөн голомт руугаа харна) голомт хаана байхад үүсэх вэ?

A. Духны дэлбэн

B. Чамархайн дэлбэн

C. Дагзны дэлбэн

D. Зулайн дэлбэн

E. Гипоталамус

/96./ Горнерийн гурвал хам шинж ямар бүтэц гэмтэхэд үүсэх вэ?

A. Одон зангилаа

B. Наран сүлжээ

C. C1-C2 түвшинд нугасны урд эвэр

D. C8-T1 түвшинд нугасны хажуу эвэр

E. C8-T1 түвшинд нугасны урд эвэр

/97./ Олон жилийн артерийн гипертоной өвчтөн, хэлээ амнаас гүйцэд гаргахгүй. Өөрөө ярихгүй боловч, хэлж ярьсныг бүрэн ойлгоно. Хүчилж инээнэ.

- A. Хуурамч бульбар саа
- B. Бульбар саа
- C. Ярихын хэлгүйдэл
- D. Нэрлэхийн хэлгүйдэл
- E. Сэтгэцийн органик хам шинж

/98./ Мэдрэхүйн тэнцвэргүйдлийг илрүүлэх арга:

- A. Нэг шугамын дагуу алхуулах
- B. Ромбергийн сорил
- C. Зогсоо байдлаас хойш гэдийлгэх
- D. Нүдийг аниулж алхуулах
- E. Хэвтээ байдалд гараа цээжин дээр зөрүүлж тавьсан байдлаас өндийлгэх

/99./ Нуруу –суурийн артерийн савд үл багтах судас

- A. Тархины өмнөд артери
- B. Тархины хойд артери
- C. Нурууны артери
- D. Бага тархины дээд артери
- E. Нугасны өмнөд артери

/100./ Гарын сарвуу, тавхайн хүч буурч, булчингууд хатингиршсан. Тэнцвэр муу, харанхуйд илүү бүдчинэ. Хамшинжийн онош:

- A. Ёзоорын хамшинж
- B. Полиневритийн хамшинж
- C. Дөрвөн мөчний сул саа
- D. Тэнцвэргүйдэл
- E. Мононеврит хамшинж

/101./ Эпилепситэй өвчтөний эмийн эмчилгээг юунаас хамааруулж тогтоох вэ?

- A. Уналтын хэлбэр
- B. Уналтын явц
- C. Уналтын давтамж
- D. ЭЭГ-ийн онцлог
- E. Дээрхи бүгд

/102./ Өвчтөний зөөлөн тагнай зүүнд саажсан, хүүхэн хэл баруун тийш хазайсан, баруунд рефлексүүд өндөр ба эмгэг рефлекс илэрсэн бол голомт хаана байрлах вэ?

- A. Уртавтар тархи 9, 10-р мэдрэлийн түвшинд зүүнд
- B. Уртавтар тархи 12-р мэдрэлийн түвшинд
- C. Уртавтар тархи 11-р мэдрэлийн түвшинд
- D. Дотор капсулын хойд өвдөг зүүнд
- E. Гипоталамус

/103./ Тархмал хатуурлын үед булчингийн чангарлыг сулруулахад хэрэглэх бэлдмэл.

- A. Карбамазепин
- B. Тебантин
- C. Цитиколин
- D. Баклофен
- E. Ламотриджин

/104./ Хүүхэн хараа нэг талд өргөссөн, гэрлийн урвал сул, зохицох дотогшлох урвал хэвийн. Тухайн тохиолдлын гэмтсэн бүтцийг нэрлэх:

- A. Якубовичийн бөөм
- B. Перлийн бөөм
- C. Гадагшлуулагч мэдрэл
- D. Буланцар мэдрэл
- E. Дагзны дэлбэн

/105./ Ахимаг насны эрэгтэй хальтарч унаад 4 мөч саажсаж, шээс, өтгөн хоригдсон. Хүзүүний ясны зурагт бүтцийн өөрчлөлт үгүй.

- A. Хүзүүний ясны хугарал
- B. Гематомиели

- C. Миелит
- D. Хүзүүний миелопати
- E. Нугасны хавдар

/106./ 12 настай охины анхаарал төвлөрөл муудсан. Бичгийн хэлбэр өөрчлөгдсөн. Амархан гомдож уйлна. Гордон- 2 рефлекс үүснэ.

- A. Тик
- B. Зан төрхийн эмгэг
- C. Бага хорей
- D. Хүүхдийн невроз
- E. Дотоод шалтгаант сэтгэцийн эмгэг

/107./ Өвчтөн гавал тархины гэмтэл авснаас хойш 3 хоногийн дараа гэнэт ухаан алдаж татсан. Хүүхэн хараа ижил бус болсон. Тархины бүрхүүл цочролын шинж илэрнэ.

- A. Менингит
- B. Тархины буглаа
- C. Тархины няцрал
- D. Тархи доргилт
- E. Тархины хатуу хальс дорх цус харвалт

/108./ Булчин мэдрэлийн доорхи өвчнүүдээс удамшлын бус шалтгаант өвчнийг заах:

- A. Миодистрофи
- B. Амиотрофи Шарко-Мари
- C. Бейкерын миопати
- D. Миастени
- E. Миотони

/109./ Өвчтөн харанхуй бүрийд илүү гуйвана. Хөлөө дээр өргөж, дэвсэж явна.

- A. Бага тархины тэнцвэргүйдэл
- B. Нугасны тэнцвэргүйдэл
- C. Вестибуляр тэнцвэргүйдэл
- D. Духны тэнцвэргүйдэл
- E. Мэдрэхүйн тэнцвэргүйдэл

/110./ Хүзүү зүүн тал руу гилжийнэ. Явах үед улам чангарч татагдана. Тайван үед багасна. Хүзүүний хөдөлгөөн чөлөөтэй.

- A. Хүзүүний радикулопати
- B. Торсин дистони
- C. Төрөлхийн хүзүүний гилжгий
- D. Хүзүүний спондилез
- E. Хүзүүний ясны гэмтэл

/111./ Өглөө сэрэхэд баруун сарвуу унжсан. Урьд орой нь архи уусан. Таны тавих урьдчилсан онош

- A. Тохойн сувгийн хамшинж
- B. N.radial невропати
- C. Мөрний сүлжээний эмгэг
- D. N.medianus невропати
- E. Полиомиелит

/112./ Менингитын оношлогооны хамгийн чухал хэмжүүр:

- A. Халуурч огцом эхлэл
- B. Мэнэн хамшинж илэрч огцом эхлэх
- C. Тархи-нугасны шингэний өөрчлөлт
- D. Халдвар-хордлогын шокийн шинж
- E. Өвчний анамнез

/113./ Өвчтөнд тал хараагүйдэл, талласан тэнцвэргүйдэл, талласан мэдээгүй илэрсэн. Голомт хаана байна вэ?

- A. Цайвар бөмбөлөг
- B. Сүүлт бөөм
- C. Улаан бөөм
- D. Таламус
- E. Хар биет

- /114./ Уотерхаус – Фридериксен хам шинж ямар өвчний хүндрэл болж илэрдэг вэ?
- A. стафилококк менингит
 - B. пневмококк менингит
 - C. вирус Коксакийн менингит
 - D. менингококк менингит
 - E. лимфоцит хориоменингит
- /115./ Гурвалсан мэдрэлийн невралгийн онцлог:
- A. Нүүр талласан байнгын өвдөлт
 - B. Нүүрэнд хүрэхэд огцом хүчтэй цоргисон богино өвдөлт
 - C. Нүдний уг орчим эрчилсэн өвдөлт, нулимс гоожино
 - D. Нүдний ухархай руу үргэлжилсэн өвдөлт, хараа муудна
 - E. Нүүр таллаж өвдөнө, толгой эргэнэ
- /116./ Биеийн байрлалаа мэдэхгүй болох нь аль голомттой холбоотой вэ?
- A. Давамгайлагч бөмбөлгийн чамархайн дэлбэн
 - B. Давамгай бус бөмбөлгийн чамархайн дэлбэн
 - C. Давамгайлагч бөмбөлгийн зулайн дэлбэн
 - D. Давамгай бус бөмбөлгийн зулайн дэлбэн
 - E. Гипоталамус
- /117./ Нугасны хавдрын үед тархи-нугасны шингэнд илрэх өөрчлөлт
- A. Эс-уургийн зөрүү
 - B. Уураг-эсийн зөрүү
 - C. Раздольскийн шинж сөрөг
 - D. Квекенштедтийн сорил сөрөг
 - E. Цустай гарна
- /118./ Нүдний завсар баруун талд нарийн. Хүүхэн хараа ижилгүй OD<OS. Нүдний алимны хөдөлгөөн чөлөөтэй.
- A. Нүд хөдөлгөгч мэдрэлийн гэмтэл
 - B. Аргайл-Робертсоны хам шинж
 - C. Горнерийн хам шинж
 - D. Вестибуляр мэдрэлийн гэмтэл
 - E. Тиреотоксикозийн офтальмомиопати
- /119./ 6 настай хүү орчинд сонирхолгүй болж, цөөн ганц нэг үгээр ярих болсон. Нойр муутай, үүрээр голцуу татаж, ухаан алдаж, орондоо бие засдаг. 2 сарын дараа зүүн талын талласан саа, баруун талд баллистик маягийн эмгэг хөдөлгөөн үүссэн. Толгой өвдөх, бөөлжих шинжгүй. Тархины КТ-д “Даусоны хурууны” шинжтэй.
- A. Лейкоэнцефалит
 - B. Тархины хавдар
 - C. Удамшлын эмгэг
 - D. Эпилепсийн тэнэгрэл
 - E. Бодисын солилцооны энцефалопати
- /120./ Байгуулахын үйлдэлгүйдэл илрүүлэх арга:
- A. Гарыг өргүүлэх
 - B. Баруунг гараар зүүн чихийг бариулах
 - C. Шүдэнзний модоор дүрс бүтээлгэх
 - D. Дагуулж дуурайлган хөдөлгөөн хийлгэх
 - E. Тоо тоолуулах
- /121./ Мийяр-Гублерын сүлжээ саа голомт хаана байрлахад үүсдэг вэ?
- A. Тархины хөлийн суурь
 - B. Уртавтар тархины ар хажуу хэсэгт
 - C. Улаан бөөмсийн орчим
 - D. Гүүрний доод хэсэгт
 - E. Гипоталамус
- /122./ Амьсгалын төвийг дарангуйлдаг бэлдмэлийг нэрлэх:
- A. Седуксин
 - B. Кокаин
 - C. Лобелин

D. Промедол

E. Баклофен

/123./ Тархины шигдээстэй өвчтөний КТ-д голомтот өөрчлөлт өвчин эхэлнээс хойш ямар хугацаанд илэрч харагдах вэ?

A. 1 цагийн дараа

B. 2 цагийн дараа

C. 4 цагийн дараа

D. 6 цаг ба түүнээс дээш

E. Өвчин эхэлснээс хойш 2 дах хоногт

/124./ Өвчтөн хальтирч унаад 4 мөч саажсан, шээс, өтгөн хоригдсон. Хүзүүний ясны зурагт бүтцийн өөрчлөлт үгүй.

A. Хүзүүний ясны хугарал

B. Гематомиели

C. Миелит

D. Хүзүүний миелопати

E. Нугасны хавдар

/125./ Тархины суурь ясны гэмтлийн онцлог шинж:

A. чихнээс цус гоожих

B. чихнээс тархи-нугасны шингэн гоожих

C. тархи-нугасны шингэн цустай

D. А,В зөв

E. Бүгд зөв

/126./ Булчин-мэдрэлийн синапсын медиаторыг нэрлэх:

A. Допамин

B. Адреналин

C. Ацетилхолин

D. Норадреналинин

E. Серотонин

/127./ Мэс заслаар үл эмчлэх хам шинж

A. Арнольд-Киарийн хам шинж

B. Нугасны ивэрхий

C. Аневризм

D. Гидроцефали

E. Порэнцефали

/128./ 24 настай эрэгтэй, гэнэт бөөлжиж, ухаан самуурсан. Үзэхэд: сэтгэц хөдөлгөөний хөөрөлтэй. Дагзны булчин 2 хуруу хөшингө. Хийх шинжэлгээ.

A. Нүдний уг

B. Тархины КТ

C. Гавлын ясны зураг

D. Нугасны хатгалт

E. ЭЭГ

/129./ Зүүн гарын бугалганы булчин эрс хатингир, 2 ба 4 толгойт булчингийн шөрмөсний рефлексүүд үүсэхгүй. Өвдөлт, t° мэдрэхүй хэвийн. Байршлын онош

A. өмнөд төв атираа

B. арын төв атираа

C. нугасны өмнөд эвэр C5-th1

D. нугасны арын эвэр C5-th1

E. нугас хөндлөн огтлол C5-th1

/130./ Тархины аль дэлбэн гэмтэхэд астереогноз илрэх вэ?

A. Зулайн дэлбэнгийн хэлт атираа

B. Зулайн дээд атираа

C. Духны доод атираа

D. Зулайн дээд дэлбэнцэр

E. Бага тархи

/131./ Дунд насны зэрэгтэй, гарын үзүүр чичэрч салгална. Архи уухад салганал зогсдог. Сэтгэл хөдлөлөөр ихэснэ.

- A. Архидалтын салганал
 - B. Физиологийн салганал
 - C. Невроз
 - D. Бамбайн хордлого
 - E. Удмын салганал
- /132./ Тархмал хатуурлын үед тархины MRI –н өөрчлөлтийн сонгомол бус байрлал
- A. Хажуу ховдол тойрсон
 - B. Гадрын доорхи цагаан бодис
 - C. Бага тархи
 - D. Нугас
 - E. Харааны мэдрэл
- /133./ Үнэрлэхүйн хий үзэгдэл аль бүтэц гэмтэхэд гарах вэ?
- A. Үнэрлэхүйн товруу
 - B. Үнэрлэхүйн булцуу
 - C. Чамархайн дэлбэн
 - D. Зулайн дэлбэн
 - E. Духан дэлбэн
- /134./ Сирингомиели өвчний эмгэг морфологи:
- A. Нугас хөндлөн огтлолоор гэмтэнэ
 - B. Нугасны урд эвэр гэмтэнэ
 - C. Нугас таллаж гэмтэнэ
 - D. Нугасны хойд баганад хөндий үүснэ
 - E. Нугасны ёзоор дарагдана
- /135./ Тэнэгрэлийн хам шинж үүсэхгүй өвчнийг нэрлэх:
- A. Альцгемерийн өвчин
 - B. Паркинсоны өвчин
 - C. Гетингтоны хорей
 - D. Хэвийн даралтат гидроцефали
 - E. Такаясу өвчин
- /136./ 3 настай хүүхэд ялихгүй сааданд тээглэж унадаг. Гүйхдээ тааруу. Үзэхэд: 2 хөлийн эрэн булчин бага зэрэг бүдүүвтэр, борвины рефлекс үүсэхгүй.
- A. Рахит
 - B. Миопати, Дюшенны хэлбэр
 - C. Невральная амиотрофия, Шарко-Марийн хам шинж
 - D. Хөдөлгөөний хөгжлийн хоцрогдол
 - E. Перинаталь эмгэг
- /137./ Нэрлэхийн хэлгүйдэл илрүүлэх арга:
- A. Гарыг өргүүлэх
 - B. Баруунг гараар зүүн чихийг бариулах
 - C. Эд юмсыг нэрлүүлэх
 - D. Ном уншуулах
 - E. Тоо тоолуулах
- /138./ Бүсэлхийн бүдүүрлийн вентрал хэсэг гэмтэхэд гарахгүй шинжийг нэрлэнэ үү:
- A. Доод мөчдийн сул саа
 - B. Хөлд мэдэрхүй буурна
 - C. Аарцгийн үйл алдагдана
 - D. Мэдрэхүйн атакси
 - E. Гүн мэдрэхүй хадгалагдана
- /139./ Тархины цус харвалттай өвчтөний КТ-д голомтот өөрчлөлт өвчин эхэлнээс хойш ямар хугацаанд илэрч харагдах вэ?
- A. 1 цагийн дараа
 - B. 2 цагийн дараа
 - C. 4 цагийн дараа
 - D. 6 цагийн дараа
 - E. 24 цагийн дараа
- /140./ Нэрлэхүйн хэлгүйдэлтэй өвчтөний голомт хаана байрлах вэ?

- A. Духан дэлбэн
- B. Зулайн дэлбэн
- C. Дух, зулайн дэлбэнгийн уулзвар
- D. Чамархай, зулайн дэлбэнгийн уулзвар
- E. Дагзны дэлбэн

/141./ Антиагрегант бүлгийн эмэнд хамаарахгүй эмийг нэрлэнэ үү?

- A. Ацетилсалицилын хүчил
- B. Дипиридамол
- C. Клопидрогель
- D. Клонидин
- E. Тессирон

/142./ Сээрний түвшинд нугасны хөндлөн миелитын үед илрэхгүй шинжийг нэрлэнэ үү:

- A. Доод мөчний саа
- B. Аарцгийн эрхтэний алдагдал
- C. Мэдрэхүйн дамжуулах хэвшинжийн алдагдал
- D. Тархи-нугасны шингэний урсгалд саад үүсэх
- E. Ууц, өсгий цоорох

/143./ Залуу эмэгтэй АД үе үе ихсэж, зүрх дэлсэнэ. Амьсгал давчдана, айдас төрнө. Гэнэт толгой эргэж, юу болсныг санахгүй.

- A. Вегетатив судасны хөдлөл
- B. Синкоп
- C. Эпилепсийн уналт
- D. Муужралт
- E. Зүрхний шигдээс

/144./ 45 настай залуу, зүүн гарын хурууны хөдөлгөөн бага зэрэг хязгаарлагдмал, халуун, хүйтэн, өвдөлтийн мэдрэмж, мөрнөөс хөхний шугам хүртэл алдагдсан. Баруун гар, 2 хөлийн хөдөлгөөн чөлөөтэй. Мэдрэхүй хэвийн.

- A. Мэдрэхүй сегментийн хэв шинжээр алдагдсан
